

## 1911 ОНООС ӨМНӨХ ОЛОН УЛСЫН ХАРИЛЦААНЫ СИСТЕМД МОНГОЛЫН ЭЗЛЭХ БАЙР СУУРЬ

Б.Доржханд\*

**1** 904-1905 оны Орос Японы дайны дараагаар Алс Дорнодод олон улсын харилцааны систем бүрэлдэн тогтоход дараах хүчин зүйлс нөлөөлсөн байна.

Үүнд:

1. Хятадад Японы зүгээс үзүүлэх улс төр, эдийн засгийн нөлөө улам бүр нэмэгдсэн.
2. Англи, АНУ-ын зүгээс Японы нөлөөг аль болохоор сулруулж ингэснээрээ Хятадад эзлэх өөрсдийн байр суурийг бэхжүүлэхээр оролдож байв.
3. Аль эртнээс маргаантай байсан Манжуур, Монголын газар нутагт Орос болон Япон харилцан тохиролцож энх тайвны замаар өөрсдийн “нөлөөллийг” тус бүрдээ тогтоохоор зорьж байв. Ингэхдээ Монгол ба Хойд Манжуурыг Оросын мэдэлд, Өвөр Монгол ба Өмнөд Манжуурыг Японы мэдэлд үлдээхээр шийдвэрлэж энэ тухайгаа 1907, 1910 оны хэлэлцээрээр баталгаажуулжээ.

Монгол нь ХҮИ зууны сүүлчээр Чин Хятадын бүрэлдэхүүнд хязгаар хэсэг нь болсон байв. Энэ үед Монголын олон улсын эрх зүйн байдал нь XIX зууны дунд үед байгуулсан Орос-Хятадын гэрээ, хэлэлцээрийн системийн хүрээнд XIX зууны эцэс XX зууны эхээр Хятадын зүгээс явуулж эхэлсэн “шинэчлэлийн” бодлогын үр дүнгээр тодорхойлогдож байв.

Энэ үед Монголд орж ирж байгаа Хятадын капиталын бүх хязгаарлалтыг хүчингүй болгосноор Монголын газар нутгийг колоничлон эзлэх замыг нээсэн хэрэг байлаа. Орос, Хятад хоёрын хоорондын сөргөлдөөн нь Монголын олон улсын байдлыг тодорхойлогч гол элемент байсан юм. Ер нь энэ үеийн Орос, Хятадын харилцаа нь зөвхөн газар нутаг түүхийг бус арай өргөн хүрээтэй соёл иргэншил хоорондын утга учир бүхий өргөн харилцааны тусгал нь байв. Энэхүү түүхэн маргааны орчимд бүхэл бүтэн бага үндэстний хувь заяа шийдэгдэж байлаа. Монголын ард түмэн уг сөргөлдөөний голомтонд нь байж улмаар 1911 он гэхэд гурван “бие даасан” хэсэг болж Монгол, Өвөр Монгол, Буриад гэж хуваагдсан юм. Гэхдээ Өвөр Монгол нь Хятадтай улс төр, эдийн засгийн хувьд олон тооны сувгаар бат холбоотой байсан бол Монгол нь өөрийн үндэстний өвөрмөц байдлаа хэвээр хадгалж чадсан бөгөөд Оросын эзэнт гүрэнд талтай хандаж байв.<sup>1</sup>

\*Өвөр Монголын Их Сургуулийн докторант

1. С.Г.Лузянин “Россия-Монголия-Китай в первой половине XX в” Москва.2003. с.45

Оросын зүгээс Монголд явуулж байсан бодлого нь юуны өмнө аж ахуй, эдийн засгийн ашиг сонирхолтой холбогдож байсан болно. Энэ нь эзэнт гүрний Алс Дорнодод явуулж байсан улс төрийн бодлогын чухал бүрэлдэхүүн байв. Алс Дорнодод улс төр, эдийн засгийн нөлөөллийн “бүс нутаг”-ийг бий болгох нь дээрх бодлогын чухал хэсэг байжээ. 1904 он гэхэд Оросын нөлөөллийн бүс нь Хойд Манжуур, Монгол, Шиньжаан гэсэн болзмол шугамаар хязгаарлагдаж байлаа. 1904-1905 оны Орос Японы дайны үр дүнд Орос улс өмнөд Манжуур болон Өвөр Монголд нэвтрэх аргагүй болжээ. Ингээд 1907, 1910 оны Орос Японы хэлэлцээрээр Монгол, Хойд Манжуурт оросууд нөлөөгөө тогтоож, харин Өвөр Монгол, өмнөд Манжуур, Солонгосыг Япончууд нөлөөллийн хүрээндээ багтааж авчээ.

Оросын нөлөөллийг Монголд бэхжүүлж байх үндсэн арга нь Орос, Монголын уламжлалт худалдаа байв. Энэ худалдаа ХХ зууны эхээр 16 сая 900 мянган рубльд хүрсэн нь XIX зууны дунд үеийнхтэй харьцуулбал 80 дахин өсчээ.<sup>2</sup> Энэхүү худалдаа нь гадаад хэлбэрээрээ больхи (оросын барааг мал малын гаралтай бүтээгдэхүүн, түүхий эдээр сольдог) байсан хэдий ч хүнд хүчир, төвөгтэй ажил байв. Худалдаа хуурай замаар явагдаж байлаа. Хиагтаар ердийн хөсгөөр явж байсан бол Чуйскийн хавцлаар тэмээн жингээр бараа таваарыг зөөдөг байв. Худалдаа нь Орост нийлүүлэх импортын хэмжээгээр өсч байсан юм. 1907 онд 9,5 сая рубль, 1910 онд 12 сая рубль хүрч байлаа.<sup>3</sup>

Монголын зах зээлээс Орост хямд мах, түүхий эд нийлүүлэх болжээ. Хэвлэл болон худалдааны тусгай мэдээллүүдэд дурьдсанаар Монголд (Өвөр Монголыг оруулаад) 50 сая бод мал, 80 сая бог мал, 25 сая адуу<sup>4</sup> байдаг гэсэн мэдээ байна. Үүнээс үндэслэн жил бүр 450 мянган толгой малыг Өмнөд Сибирь болоод бусад бүсэд тууж авчрах тухай яригдаж байлаа. Ингэснээр Монгол Оросын худалдааны эргэлт 16 сая рублээс 30-35 сая рубльд хүрэх тооцоо байжээ. Оросын худалдаа аж үйлдвэрийн нөхдүүд 1908 он гэхэд жил бүр 339 мянган бод, бог малыг Кош Агач болон Хиагтаар дамжуулан саадгүй оруулах ажлыг зохион байгуулж чадсан байдаг.<sup>5</sup> Харин экспортын хувьд авч үзвэл гайхуулахаар үзүүлэлт гараагүй болно. Худалдаанд гаалийн татвар (1881 оны Орос-Хятадын гэрээгээр) ноогдуулаагүй байхад экспортын хэмжээ импортоос хоёр дахин бага байлаа. Ингэж экспортоороо бусад улсаас хоцрогдож байсан нь зөвхөн улс төрийн учир шалтгаанаас гадна (Халх Монголд байгаа Хятадын албан

2. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын түүх 1604-1917. 2 боть –УБ. 1983. Т.242

3. Российский государственный исторический архив (Санкт-Петербург), ф.23, оп 1, д.325, л.8 –Далее РГИА (СПб).

4. Торгово-промышленная газета-1912. 11 (24) января Московские ведомости. -1913.20 февраля (5 марта).

5. Архив востоковедов Санкт-Петербургского института востоковедения РАН, ф.66 (Б.М. Гурьев), д 2, л 32

хаагчдын Оросын эсрэг үзэл, Өргөө Бээжинд захирагдаж байсан) цэвэр эдийн засгийн шалтгаан байсан юм. Тухайлбал, Москвагаас Бийск хүртэл бараа татах зардал нь 1 пуд ачаанд 1 рубль 46 копейк болж байсан нь тухайн барааг Монголын зах зээлд борлуулахад хүндрэл учруулж байсан юм.<sup>6</sup> Оросын бөс барааны нэг аршин нь Ирбитийн яармаг дээр 1 рубль 85 копейк болж байсан бол Хятадын худалдаачид ийм хэмжээний даалимбыг 1 лангаар арилжиж байв. Энэ нь 1рубль 40-1рубль 45 копейкын хооронд хэлбэлзэж байна гэсэн үг юм.<sup>7</sup> Транссибирийн төмөр зам ашиглалтанд орсны дараа ч гэсэн Хиагтын чиглэл, Эрхүү болон Дээд Үдийн яармаг дээр үнийн зөрүүтэй байв.

Оросын засгийн газар энэ байдлыг өөрчлөх оролдлого хийж 1909 онд худалдаа аж үйлдвэрийн яамны дэргэд Монголын асуудал хариуцсан байгууллага дундын онцгой зөвлөх газрыг байгуулжээ. Мөн зах зээл судлах хэд хэдэн экспедицийг зохион байгуулжээ. Засгийн газар болоод хувийн хөрөнгө оруулагчдын зүгээс ихээхэн чармайлт гаргасан боловч 1911 он гэхэд Оросын экспортод төдийлөн сайнаар нөлөөлсөн зүйл ажиглагдсангүй. Хятадын худалдаачид Монголын зах зээл дээр давуу эрхээ хадгалсаар байв. Оросын худалдаа гол төлөв “хошуудын худалдаачдын”<sup>8</sup> уламжлалт системд суурилагдсан учраас хоцрогдсон нь илт байлаа. Үүний оронд Монголын олон газарт худалдааны пүүс, зээлийн байгууллагуудыг үүсгэн зохион байгуулах шаардлагатай байв.

Орос, Монголын харилцаа өвөрмөц байдлаар хөгжиж ирсэн юм. Энэ нь Оросын нөлөөний газар нутагт Монголчуудын үндэс угсааны омог аймаг амьдран сууж ирсэнтэй холбоотой. Буриад Монгол болон Урианхайн омгууд ХҮИ зууны үед салан тусгаарлаж XIX зууны дунд үеэс Оросын колоничлолд хамрагдан XIX зууны эцэс XX зууны эхэн гэхэд Оросын улс төрийн бодлогыг Монголд хэрэгжүүлэхэд гол хүчин зүйл нь болсон юм. Оросын буриадууд, Монголчуудын шүтдэг шашин ижил байсан нь мөргөлийн үйл ажиллагаанд харилцан оролцох бололцоог улам бүр нэмэгдүүлж байжээ. Энэ нь алсдаа Өмнөд Сибирь Байгалийн чанад дахь нутаг болон Хойд Монголын хооронд эдийн засгийн холбоо бүрэлдэн тогтоход нөлөөлжээ. Иймэрхүү үзэгдэл нь тухайн үедээ Агваан Дорж, Петр Бадмаев нарын онцгой зүтгэлтнүүдийг гаргаж ирсэн ба тэдний хүчин зүтгэлийн ачаар Орос, Монгол, Түвдийн хоорондын харилцаанд хүчтэй нөлөө үзүүлжээ. Нэгдсэн ижил угсаатны орон зай нь хил орчмын колоничлолын бодлогод таатай хөрс нь болж хувирсан байна. Сибирийнхэн, Буриадууд, халх Монголчуудын аж ахуйн чанартай

6. Сибирийн худалдаачин А.Д. Васеневын тэмдэглэл –Барнаул, 1994. Ч 1 С 20.

7. Мөн тэнд. С. 87

8. Бурдуков А.В В старой и новой Монголии Воспоминания: Письма-М., 1969, Даревская Е.М. Письма И.М. Майского А В Бурдукову //Монголика-3. Из Архивов отечественных монголоведов XIX-нач XX вв –СПб, 1994 С 45-57

харилцаа нь ямар нэг асуудалгүйгээр аяндаа хөгжиж байв. Америкийн нэрт Монголч эрдэмтэн О.Латтимор “Сибирчүүд өмнөд зүгт урагшлах бүрдээ монголчуудаас сүх, зэр зэвсэг, анжис зэргийг авч улмаар ойн захад тархан суурьшсан билээ”<sup>9</sup> гэж бичсэн байдаг.

Орос улс 1911 он хүртэл Монголд улс төрийн хувьд Хятадын эсрэг бодлого явуулж байлаа. Тэд Чин улсын дэглэмийн эсрэг тэмцэж буй Монголын хэсгийн толгойлогч нарыг дэмжихийн зэрэгцээгээр Халх Монголын үндэсний өвөрмөц байдал, тусгаар тогтнолоо хадгалах гэсэн шашны болон дээд ангийн төлөөлөгч нарыг дэмжиж байв. Тухайлбал Бээжинд суугаа Оросын элчин И.Я.Коростовец 1909-1910 онуудад Петербурт илгээсэн илтгэлдээ: Монголыг тусгаар тогтносон улс болгох зайлшгүй шаардлагатай байгааг бичээд “Ар монголын талаар явуулах бодлогын тухайд тодорхой программ дэвшүүлэн ажиллах”-ыг уриалжээ.<sup>10</sup> И.Я.Коростовецийн саналыг Монголд сууж байсан Оросын төлөөлөгчид (И.Я.Шишмарев, В.Н.Лавдовский, В.Н.Люба) дэмжиж байсан бөгөөд Оросын ГЯЯ-ны удирдлага тодорхой хэмжээгээр ойлгож байв. (А.П.Извольский, А.А.Нератов, С.Д.Сазонов)<sup>11</sup> Гэсэн хэдий ч ийм ойлголт Монголын удирдагч нарыг дипломат шугамаар дэмжихээс цааш гарсангүй. Хаант засгийн газар Монгол-Хятадын зөрөлдөөнд ил тодоор оролцохыг хүсэхгүй байлаа. Түүнчлэн Ар Монголыг Хятадаас бүрмөсөн тусгаарлах саналыг ойшоон дэмжихгүй байв. Бас Оросын харьяалалд Монголыг оруулах асуудлыг ч бүр авч хэлэлцэхгүй байсан болно. Дээрх байдлууд нь Оросын удирдлагын үзэж байгаагаар нэгэнт тогтсон хүчний тэнцвэрийг алдагдуулж улмаар Орос-Хятад, Орос-Японы харилцааны сонирхолд үл нийцнэ гэж үзэж байв. Оросын гадаад бодлого нь эцсийн дүндээ энэ бүс нутагт “статус-кво”-г хэвээр нь хадгалахад оршиж байсан юм.

Монгол дахь Хятадын оролцоо нь Монгол Оросын хамтын ажиллагаатай харьцуулахад илүү давуу талтай байсан юм. Энэ нь:

1. Монголын улс төрийн засаглалын статус нь Бээжинд илүү тохиромжтой байсан бөгөөд тэд өөрийн нутагт байгаа мэт чөлөөт үйл ажиллагаа явуулж байв. Нөгөө талаар Өвөр Монголыг хойт зүгийн нөлөөгөө бэхжүүлэх хэрэгт бааз суурь болгон ашиглаж байлаа.
2. Монголд хятад худалдаачдын байр суурь бэхжсэн явдал нь Хятадын хувьд ашигтай байв. Орос улс Японтой хийсэн дайнд ялагдсан нь Бээжингийн зүгээс Монголд илүү анхаарах боломжийг олгосон бөгөөд 1905 оноос хойш Орос улс Алс Дорнодод анхаарлаа хандуулах нь суларсныг далимдуулах хандлага илт ажиглагдах болжээ. 1906 онд

9. Lattimore O. Nomads and Commissars. Mongolia Revisited. –New-York, 1962.P.69

10. АВСПО ИВ РАН, ф44 (фонд А.М. Позднеева),оп 1, д 198 Л.1 д.203, л 22

11. Мөн тэнд 22-24

Чин улсын засаг захиргаа “Монголд шилжин суугчдын товчоо” хэмээх улсын байгууллагыг Бээжинд байгуулж улмаар Су хэмээх төлөөлөгчийг Өргөөнд томилон явуулсан байна. Энэхүү түшмэл Су Монголын эдийн засгийн боломжыг нарийвчлан судлаад тусгай илтгэл бичиж засгийн газрын дээд тушаалын түшмэдүүдэд танилцуулжээ. Уг илтгэлд хамгийн түрүүнд олон тооны шилжин суугчдыг байршуулан колоничлоход тохиромжтой газар нутгийн талаар тодорхой оржээ. Түшмэл Су-гийн төлөөнийхөн 1907 оноос эхлээд Өргөө болон Монголын бусад хот суурингуудад Халх Монголд Хятадын колоничлогчдыг байршуулах зорилгоор Манж Монголын комиссыг үүсгэн ажиллуулж эхлэв. Энэ комисст гол төлөв нөлөө бүхий ноёд түшмэдийг дайчлан оролцуулсан байна. Түүнчлэн тэдгээр нутагт тариа тарих болон бусад аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх боломжийг судалж байжээ. 1909 онд дээр дурьдсан комисс Хятадуудад зориулсан тариалангийн газрыг эзэмшүүлэх зорилготой хэд хэдэн төслийг бэлэн болгосон байна. 1911 он гэхэд Бээжин хилийн монгол харуулын отрядыг Манж-Хятадын цэргээр сольсон байна. Мөн Өргөө болон Монголын зарим хотуудад Хятадын цэргийн нэмэлт ангиудыг байршуулав. 1911 оны хавар хурандаа Танаар ахлуулсан цэргийн төлөөлөгчид Монголын нийслэлд ирсэн байна. Тэд Хятадын цэргийн шинэ анги нэгтгэлүүдийг тараан байршуулах асуудлыг хариуцаж байлаа. Манай Монгол улс нь түүхэн нөхцөлд Орос, Хятадын улс төрийн бодлогын идэвхигүй объект байсан юмуу? гэсэн асуулт гарч ирнэ.

Нэн шинэ үеийн судалгаа, архивын баримтуудаас үзэхэд Монголын язгууртнууд хойд болон өмнө зүгийн хөршөөс үзүүлж буй дарамт, шахалтыг тэсвэрлээд зогсохгүй өөрийн улсын онцлог байдлыг хэвээр хадгалж улмаар Хятадын уусгах бодлогын түрэмгийллийн эсрэг адил хэмжээний үр ашигтай улс төрийн чиг шугамаа сэргүүлэн тавьж чадсан юм. Энэхүү бодлогыг хэрэгжүүлэхдээ бий болсон бодит байдлыг зөвөөр ашиглаж чадсан байдаг. Тухайлбал Орос-Хятадын харилцааны хүрээнд байр байдлаа зөв зохицуулан тодорхойлох, Орос-Хятадын хоорондын зөрчилдөөнийг ашиглах, Орос улсыг чиглэсэн уламжлалт харилцааг ашиглах, дундад зууны үеэс эхтэй панмонголын үзлийг сэргээх<sup>12</sup> энэ үзлийг Монгол улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт Монгол улсыг байгуулах үйлст ашиглах, Хятадын дотоодод улс төрийн бодлого эдрээтэй болсон үеийг өөрийн ашиг сонирхолын үүднээс ашиглах, 1911-1913 онуудад Чин улс задран бутарч Синьхайн хувьсгалын эхэлсэн үеийг чадварлаг ашигласан гэх мэт болно.

12. Панмонголын үзэл гэдэг нь бүх монгол хэлтэн ястныг нэгтгэх гэсэн шашин улс төрийн хөдөлгөөн юм. Ингэснээр Чингис хааны их гүрний үеийн уламжлалыг дахин сэргээж Их Монгол улсыг шинээр үүсгэн байгуулах явдал юм. ХҮП зууны үеэс эхлэн Монголыг Хятадын бүрэлдэхүүнд багтаасан болон Шарын шашны лам нарын үүрэг роль нэмэгдсэн энэ үед панмонголч үзэл Богдын шашны төр болон Хятадын эсрэг хөдөлгөөнтэй холбогджээ.

Монголыг бүрэн тусгаар улс болгох чиг хандлага Монголын эрх баригчдын хүрээнд 1905-1910 оны үед үүсч бүрэлдсэн юм. Энэ байдалд дараах хүчин зүйлс нөлөөлжээ. Үүнд:

1. 1905 оноос хойш Монголд Хятадын арга явуулга улам бүр хүчээ авсан
2. 1904-1906 онд Түвдийн шашны тэргүүн XIII Далай лам Өргөөнд морилон ирсэн нь Монголчуудад онцгой нөлөө үзүүлжээ.

Оросын тагнуулын Өргөөнөөс мэдээлэхдээ: “Далай ламын айлчлалын уршгаар Монголын дээд лам нар Хятадаас тусгаарласан бие даасан улсаа байгуулах талаар тохиролцон шийдвэрээ гаргасан байна”<sup>13</sup> гэжээ. Оросын засгын газар бэлтгэгдэж буй ажиллагааны талаар мэдээлэлтэй байсан хэдий ч үйл явцад хутгалдан оролцох боломжгүй байсан тул “дагалдан тоглогч” ажиглагчийн байр суурийг баримталсан болно. Монголд байгаа дипломат болон цэргийн зөвлөхүүдэд зориулж Оросын засгийн газар зааварчилгаа гаргасан бөгөөд түүндээ “Монголын ба Хятадын засаг захиргааны хоорондын харилцаанд хөндлөнгөөс оролцохгүй байхыг” сануулжээ.<sup>14</sup>

Монголдахь Японы оролцоо Орос, Хятадыг бодвол нууцлагдмал, хэмжээ далайцаараа бага байсан юм. 1902 оноос эхлэн Монголын зах зээлээс ноос, ноолуур, арьс шир авах зорилготой Японы худалдааны пүүсүүд үзэгдэх болжээ. 1910 онд Өргөөнд Японы худалдаа аж үйлдвэрийг төлөөлсөн Хун Ли гэгч ирсэн байна. Тэрээр Японы капиталын оролцоотойгоор Монголд алт, нүүрс болоод бусад ашигт малтмал олборлон боловсруулах үйлдвэрүүдийг бий болгох зорилготой байлаа.<sup>15</sup> Монголын байдлыг Япон улс төрийн үүднээс судлах ажлаа өөрийн тагнуулуудаар дамжуулан нухацтай хандаж байв. Мэдээллийг Токиод тогтмол хүлээн авч дараах асуудлуудыг голчлон сонирхож байв. Үүнд:

1. Монголын язгууртнууд болон ард олны улс төрийн сонирхол, хандлага;
2. Монголд үүсч өрнөж байгаа Хятадын эсрэг үндэсний хөдөлгөөн, тэдгээрийг Токиогийн ашиг сонирхолд нийцүүлэн ашиглах боломж;
3. Монголд байгаа Оросуудын байр байдал;

Бүхэлд нь авч үзвэл энэ үед Японы засгийн газар Монголд нухацтай улс төрийн үйл ажиллагаа явуулахаар төлөвлөөгүй ба 1907, 1910 оны Орос-Японы гэрээг баримтлан Алс Дорнодын “статус-кво”-г хэвээр хадгалах сонирхолтой байсан болно. Тэрхүү гэрээнд “Японы эзэн хааны засгийн газар Орос улсын Монгол дахь тусгай сонирхлыг хүлээн зөвшөөрч, тэрхүү сонирхолд хохирол учруулж болохуйц аливаа оролдлогоос татгалзахыг

13. Российский государственный военно-исторический архив, ф.2000, оп 1, д 4256, л 176-Далее. РГВИА

14. АВСПО ИВ РАН, ф66, д2, л 144-145

15. Китай, Монголия, Япония Сводка сведений, полученных в штабе Иркутского военного округа –Иркутск, 1914 С 17.

үүрэг болгоно”<sup>16</sup> гэжээ. Японы засгийн газрын хувьд Өвөр Монгол, Өмнөд Манжуур, Солонгост өөрийн нөлөөллөө хадгалах зорилготой байв.

Монголын эргэн тойрны олон улсын нөхцөл байдалд Англи-Түвдийн хүчин зүйлс тодорхой төрхийг бий болгож байлаа. Түвд болон Халх Монголчуудын шашин шүтлэгийн ижил байдал, түүнчлэн Түвдэд Английн нөлөө улам бүр өсч байгаа ялангуяа 1904 оны 8 сарын 4-нд Англи-Энэтхэгийн цэргийн ангиуд Лхас хотыг эзэлсэн Далай лам Монголд зугатан орогносон зэрэг нь Англичуудыг Монголд Орос ба Хятадын өрсөлдөгч болох магадлалыг ихэсгэжээ. Түвд болон баруун Монголд байсан Оросын цэргийн тагнуулууд энэ тухай нэг биш удаа сануулж байв. Тухайлбал, 1904 оны 3 сарын 31 нд жанжин штабын офицер В.Попов нууц мэдээндээ: “Англичууд Монголчуудын шашин шүтлэгийн нөлөөг ашиглан удахгүй баруун Монголд орж ирэх болно”<sup>17</sup> гэжээ. 1911 оноос өмнөхөн Оросын дипломатууд Түвдийн асуудалд ихээхэн болгоомжтой, хүлээцтэй хандаж байв.

Оросууд Түвдийн хурцадмал байдлын үеэр Далай ламын өөрийнх нь хүсэлтийг үл харгалзан түүнийг идэвхитэй дэмжихээс татгалзаж байсан юм. 1907 оны 8 сарын 18 нд байгуулсан Орос, Английн хэлэлцээр, 1908 оны 4 сарын 20 ний Англи-Хятадын хэлэлцээрийн дараа Орос улс тухайн нутагт Английн улс төрийн бодлогоо явуулах эрхийг Монголын хэрэгт Англи оролцохгүй гэдэг баталгаагаар сольж наймаалцжээ. Америкийн Монгол дахь ашиг сонирхол гол төлөв худалдаагаар хязгаарлагдаж байв. Эхлээд Америкийн бараа таваарыг (бүс бараа, керосин гэх мэт) Хятадын худалдаачид оруулж ирдэг байлаа. 1909 оноос эхлэн Өргөөд “Норберс К”, “Вильсон К” зэрэг америкийн худалдааны пүүсүүдийн салбар нээгдэж худалдаа зуучлалгүйгээр шууд явагдаж эхэлжээ. Монголоос АНУ-руу жил бүр Тяньжиний боомтоор дамжин 200 мянган пуд ноос, 3 сая боловсруулсан арьс шир гаргаж байжээ.<sup>18</sup> 1910 онд Монголд “Стандарт Ойл Компани”, “Бритиш-Америкэн Тобаку”, “Андерсен Мейер К”<sup>19</sup> гэсэн америкийн гурван пүүсийн төлөөлөл орж ирсэн юм. Дүгнээд хэлбэл 1911 оны эхээр Монголын эргэн тойрон дахь олон улсын байдал доорх хүчин зүйлсээр тодорхойлогдож байв. Үүнд:

1. Монголын талаарх Япон, Америкийн улс төрийн бодлого идэвхжиж байлаа.
2. Монголыг Хятадын жирийн нэг муж болгон хувиргах Хятадын “шинэ” бодлого өргөн хэмжээгээр идэвхтэй хэрэгжиж эхэлжээ.

16. Баабар ХХ зууны Монгол, УБ.1996. Т.157

17. АВСПО ИВ РАН, ф66, д.2, л 143-144

18. Вестник Азии -1911. №8 С 74-76.

19. Международные отношения в эпоху империализма. Документы из архивов царского и Временного правительства. –М., 1936. Сер.2.Т.18. Ч. С 271. – Далее МОЭИ.

3. Орос-Японы (1907,1910) болон Орос-Англи хэлэлцээрийн үндэс суурь дээр тухайн нутаг дэвсгэрт “статус-кво”-г хадгалах гэсэн Оросын засгийн газрын хүсэл тэмүүлэл идэвхжсэн.

Хэдийгээр Монгол улс төрөө сэргээх явдал нь Орос, Хятадын хоорондын зөрчилдөөн, Синьхайн хувьсгал, Чин гүрний задрал зэрэгтэй холбоотойгоос гадна эрт урьдаас үргэлжилж ирсэн Монголын ард түмний тусгаар тогтнолын төлөөх хөдөлгөөн хэзээд тасраагүй юм. Нөгөөтэйгүүр Монголын ард түмний амьдрал нэн хүндэрч байсан цаг үе байв. Учир нь гадаад, дотоодын хүнд хүчир дарлал мөлжлөг, харийн түрэмгийлэн эзлэгчдийн өнгөлзлөг нь ард түмнийг улам тамирдуулж байв. Энэ бүхнээс үндэслэж 1911 онд үндэсний хувьсгал гарах урьдчилсан нөхцөл бүрэлдэн тогтоод байсан юм. Энэ нь монголын сэхээтэн голдуу тууштай эх орончид, төр засгийн албан хаагч түшмэд, лам нар тусгаар тогтнолын хөдөлгөөнийг аль эртнээс бодож төлөвлөж байсан үе юм.